ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2021 оны 02 дугаар сарын 09 -ны өдөр

№ 03

Улаанбаатар хот
Утас: 262629

Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.7, 28 дугаар зүйлийн 28.8.2, Монгол Улсын Их Хурлын 2017 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн "Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрийг соёрхон батлах тухай хууль", Монгол Улсын Засгийн газар, Олон Улсын Хөгжлийн Ассоциаци хооронд 2017 оны 07 дугаар сарын 05-ны өдөр болон 2020 оны 05 дугаар сарын 11-ний өдөр байгуулсан "Санхүүжилтийн хэлэлцээр"-ийг тус тус үндэслэн Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2020 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан "Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөр"-т хавсралтад заасан нэмэлт, өөрчлөлтийг оруулсугай.

2. "Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөр"-ийн удирдамжийг шинэчлэн батлуулж, удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллахыг Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Б.Батцэцэг/-т, хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар /Л.Дашдэмбэрэл/-т, хэрэгжилтийг хангаж, үр дүнг улирал тутам тайлагнаж ажиллахыг Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, нийслэл, дүүргийн зөвлөл, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсийн дарга нарт тус тус даалгасугай.

ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА,
САЙД А.АРИУНЗАЯА

УЛААНБААТАР ХОТ
ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2021 оны 02 дугаар сарын 09-ны өдрийн 03 дугаар тогтоолын хавсралт

Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөрийн нэмэлт, өөрчлөлт

1. Хөтөлбөрийн 3-т заасан “... 2018-2021 онд...” гэснийг “...2018-2023 онд...” гэж өөрчлөх,

2. Хөтөлбөрийн 5.2.2-т “... эхний 2 сар хүртэлх хугацаанд” гэснийг “... 6 сар хүртэлх хугацаанд...” гэж өөрчлөх,

3. Хөтөлбөрийн 5.2.5-т “Байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг...” гэсний дараа “ойлгуулах” гэж нэмэх,

4. Хөтөлбөрийн 5.3.2-ийг “...хугацаатай байна. Бизнесийн зөвлөн туслах үйлчилгээ 20-30 цагийн хугацаатай байх ба жижиг зээл авсан иргэний онцлог, хэрэгцээнд нийцсэн байна.” гэснийг “...хугацаатай байх бөгөөд сургалтыг танхим болон цахим (зайн) хосолсон хэлбэрээр зохион байгуулна. Бизнесийн зөвлөн туслах үйлчилгээ 20-30 цагийн хугацаатай байх ба жижиг зээл авсан иргэний онцлог, хэрэгцээнд нийцсэн байна.” гэж өөрчлөх,

5. Хөтөлбөрийн 5.3.7-г “... бууруулж буй байдалд хяналт тавьж...” гэснийг хасах,

6. Хөтөлбөрийн 5.3.8-д “...тогтоох,...” гэсний дараа “нэмүү өртгийн сүлжээнд холбох,” гэж нэмэх,

7. Хөтөлбөрийн 7.2-т . “...судалгаа, нөлөөллийн үнэлгээ...” гэснийг хасах,

8. Хөтөлбөрийн 7.5-д “...6 сарын дараа хэрэгжүүлнэ.” гэснийг “...6 сарын дараа зохион байгуулна.[1]” гэж өөрчлөх,

9. Хөтөлбөрийн 7.7-д “Мөшгөх судалгааг холбогдох аргачлалын дагуу судалгааны мэргэшсэн байгууллагаар гүйцэтгүүлнэ.” гэж нэмэх,

10. Хөтөлбөрийн 7.8.1.1-д “Жижиг зээл авсан иргэдийн тоо, хүйсээр” гэснийг “Жижиг зээл авсан иргэдийн тоо (2650-аас доошгүй), хүйсээр (1230-аас доошгүй эмэгтэй)” гэж өөрчлөх,

11. 7.8.1.2-д “Нийт олгогдсон жижиг зээлийн хэмжээ” гэсний дараа “(90 хувиас доошгүй)” гэж нэмэх.

-----o0o-----

[1] Мөшгөх судалгаа нь тухайн арга хэмжээнээс хойш тодорхой хугацааны дараа үр шим хүртэгчдийн нөхцөл байдалд ямар өөрчлөлт гарсныг судална (жишээ нь, хөдөлмөр эрхлэлтийн байдал, ашиг орлого, бизнесийн тогтвортой байдал, хэрэглээнд гарсан өөрчлөлт).